Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Солонгосын политехникийн коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Монгол Солонгосын политехникийн коллеж түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн элэгдлээрээ анхны өртгөө нөхөж дууссан үндсэн хөрөнгийн үнэ, ашиглах жилийг шинэчлэн тогтоолгох, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь байршуулах, хичээл, үйлдвэрлэлийн дадлагын материалын зарцуулалтыг иж бүрэн гүйцэтгэж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2026 оны 01 дүгээр сарын 26-наас 2026 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул аудит ХХК-ийн аудитор Т.Эх-Оюун, аудиторын туслах Э.Номинчулуун, нар гүйцэтгэж, захирал Ч.Мөнхтуяа анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Солонгосын политехникийн коллеж нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 1/24 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 7,235,129.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 72,351.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус коллеж нь үндсэн чиг үүрэгт хамааралгүй эрдэм шинжилгээний хурал, семинар биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулаагүй байна. Бараа үйлчилгээний бусад зардлаас 34,342.8 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 28 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд төсвийн шууд захирагчийн байршуулбал зохих 171 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 3 мэдээллийн хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,296,434.2 мянган төгрөг 26 гүйлгээ, 615,756.9 мянган төгрөгийн зарлагын 25 гүйлгээ, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1.1 “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.3 “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.5 “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор”, 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.10 “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн байршуулж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулаагүй нь Шилэн дансны тухай хууль тогтоомжтой нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Монгол Солонгосын политехникийн коллежийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж, илрүүлсэн алдаа, зөрчилд асуудлын бүртгэл хөтөлж, 2,510,155.5 мянган төгрөгийн алдаанд 5 залруулга, 6,331,032.5 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгснийг үнэлж, хэрэгжээгүй зөвлөмжийг энэхүү аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 19,592.6 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 11,061.2 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

*Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт,
албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	3	19,592.6	3	19,592.6	-	-	100.0
Зөвлөмж	2	11,061.2	2	11,061.2	-	-	100.0
Нийт дүн	5	30,653.8	5	30,653.8	-	-	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв, тодруулгуудын хамт бэлтгэж байгаа эсэхийг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,629,426.9 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцооллын 9 алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залруулав. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 320 дугаар “Үндсэн хөрөнгийн үнэ, ашиглах жил шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” тогтоолын дагуу 1,285,950.9 мянган төгрөгийн 84 ширхэг хөрөнгийн үнэ, ашиглах жилийг шинэчлэн тогтооходоо дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэсэн;
- Санхүүгийн байдлын тайлангийн тайлант үеийн үр дүнг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн дүнгээс 549,510.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан;
- Тайлант онд орлогоор бүртгэсэн хөрөнгийг данснаас хасаж, дахин үнэлгээний зардалд 24,753.2 мянган төгрөг бүртгэсэн;
- Хандиваар ирсэн 20,614.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн;
- Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын ангиллын хооронд 71,046.5 мянган төгрөгийн зөрүүтэй бүртгэсэн бөгөөд зарим орлогыг давхардуулан тусгаснаар үйл ажиллагааны орлого 775.0 мянган төгрөгөөр илүү бүртгэгдсэн;
- Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт цэвэр мөнгөн гүйлгээний дүн нь мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээс 1,020.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
- Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан дүнгээс 15,569.7 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн дүнг 293,346.5 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
- Шүүх, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 114,587.0 мянган төгрөгийн авлагыг найдваргүй авлагын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга 27, 29 дүгээр параграфт тус тус заасантай нийцэхгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 71,350.3 мянган төгрөгийн 7 зөрчил илэрснээс 6,176.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 13,810.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 51,363.5 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 71,350.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 72,351.3 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд коллежийн нэр бүхий 3 ажилтанд ээлжийн амралттай байх хугацаанд 1,529.4 мянган төгрөгийн цалин хөлс давхардуулж илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 “ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр “ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох

журам"-ын 2.8.2 “ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтын хугацаанд давхардуулан олгосон цалин хөлсийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2. Тайлант онд тус коллежийн нэр бүхий 2 ажилтанд илүү цагаар ажилласан цагийн бүртгэлгүй байхад 280 цаг илүү ажилласнаар тооцож 4,646.9 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цагийн хөлсийг нөхөн төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Жолоочийн замын хуудас бүрэн хөтлөөгүй, шатахууны тооцоог бодоогүй, шатахууны зарцуулалтын тайлан гаргаагүй 13,810.6 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасны бүртгэл бүрэн хөтлөөгүй, тооцоо бодоогүйгүйгээр шатахуун олгож байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Тус байгууллагын даргын 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/130 дугаар тушаалаар эд хөрөнгийн тооллого хийхээр тооллогын комиссыг томилж, тооллого хийгдсэн боловч хөрөнгө тоолсон тухай илтгэх хуудас, тооллогын тайлан, тооцоо бодсон акт үйлдээгүй байна

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" 73 дугаар зүйлийн 73.2 "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эд хөрөнгийн тооллогыг чанартай зохион байгуулж, тооцоог бодож, тооллогын явц, үр дүнг удирдлагад танилцуулж байх, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 2,020,329.0 мянган төгрөгийн 2855 ширхэг хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай 271 дүгээр тогтоолын 7.1 “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2 "заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хичээл, үйлдвэрлэлийн материалын зарцуулалт хийхдээ багшийн дадлагын ажил гүйцэтгэхэд шаардлагатай материалын нормын хүснэгт, сургалтын менежерийн гарын үсэгтэй материал гаргах хүсэлт, дадлагын ажлын хөтлөлт, зураг, ажлын карт, үнэлгээний хуудасгүйгээр нийт 51,363.5 мянган төгрөгийн бараа материалыг зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалын зарцуулалтыг сургалтын менежерийн зөвшөөрөлтэй материал гаргах хүсэлт, дадлагын ажлын гүйцэтгэлийг нотлох баримт бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулж, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

3. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5 "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/З дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3 "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлангийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан тодруулга тайланг бэлтгэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Монгол Солонгосын политехникийн коллежийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	1,285,950.9 мянган төгрөгийн 84 ширхэг хөрөнгийн үнэ, ашиглах жилийг шинэчлэн тогтоохдоо дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэсэн.	1	538,203.4	-	-	1	538,203.4	1	538,203.4	-	-	-	-
2	Тайлант үеийн үр дүнг 549,510.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	549,510.7	-	-	1	549,510.7	1	549,510.7	-	-	-	-
3	Орлогоор бүртгэсэн хөрөнгийг хасч, 24,753.2 мянган төгрөгийг дахин үнэлгээний зардалд бүртгэсэн байна.	1	24,753.2	-	-	1	24,753.2	1	24,753.2	-	-	-	-
4	20,614.9 мянган төгрөгийн хандивын хөрөнгийг үнэ төлбөргүй орлогод бүртгэсэн байна.	1	20,614.9	-	-	1	20,614.9	1	20,614.9	-	-	-	-
5	Мөнгөн гүйлгээний тайланд орлогын ангиллыг 71,046.5 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэж, үйл ажиллагааны орлогыг 775.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	71,821.5	-	-	1	71,821.5	1	71,821.5	-	-	-	-
6	Нийт цэвэр мөнгөн гүйлгээний дүнг мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй 1,020.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан.	1	1,020.0	-	-	1	1,020.0	1	1,020.0	-	-	-	-
7	Биет, биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 15,569.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	15,569.7	-	-	1	15,569.7	1	15,569.7	-	-	-	-
8	Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 293,346.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	293,346.5	-	-	1	293,346.5	1	293,346.5	-	-	-	-

Монгол Солонгосын политехникийн коллежийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

9	114,587.0 мянган төгрөгийн авлагыг шүүхийн шийдвэргүй найдваргүй авлагад бүртгэсэн.	1	114,587.0	-	-	1	114,587.0	1	114,587.0	-	-	-	-
Дүн		9	1,629,426.9	-	-	9	1,629,426.9	9	1,629,426.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн зөрчлийн нэгтгэл

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нэр бүхий 3 ажилтны ээлжийн амралтын хугацаанд цалин хөлсийг давхардуулан 1,529.4 мянган төгрөгийн олгосон байна.	1	1,529.4	1	1,529.4	-	-	-	-	-	-	-	-
2	Илүү цагаар ажилласан ирцийн бүртгэл байхгүй нэр бүхий 2 ажилтныг 280 илүү цаг ажилласан гэж 4,646.9 мянган төгрөг олгосон.	1	4,646.9	1	4,646.9	-	-	-	-	-	-	-	-
3	Анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасны бүртгэл бүрэн хөтлөөгүй, тооцоо бодоогүйгээр нийт 13,810.6 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.	1	13,810.6	-	-	1	13,810.6	-	-	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн тооллогод хөрөнгө тоолсон тухай илтгэх хуудас, тооллогын тайлан, тооцоо бодсон тайлан гаргаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
5	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 2855 ширхэг 2,020,329.0 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

**Монгол Солонгосын политехникийн коллежийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

6	Хичээл үйлдвэрлэлийн материалын зарцуулалт хийхдээ багшийн дадлагын ажил гүйцэтгэхэд шаардлагатай материалын нормын хүснэгт, сургалтын менежерийн гарын үсэгтэй материал гаргах хүсэлт, дадлагын ажлын хөтлөлт, зураг, ажлын карт, үнэлгээний хуудасгүйгээр нийт 51,363.5 мянган төгрөгийн бараа материалыг зарлагадсан байна.	1	51,363.5	-	-	-	-	1	51,363.5	-	-	-	-
7	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн		7	71,350.3	2	6,176.2	2	13,810.6	3	51,363.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны нэгдсэн системд 3 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл болон цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 51 гүйлгээний 1,912,191.1 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.	1	1,912,191.1	-	-	-	-	-	1,912,191.1
Дүн		1	1,912,191.1	-	-	-	-	-	1,912,191.1



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 25/A0150458

Улаанбаатар хот

САГ-2026/108/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Солонгосын политехникийн коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд тус коллежийн хавсралтад дурдсан нэр бүхий 2 ажилтанд илүү цагаар ажилласан цагийн бүртгэлгүй байхад 280 цаг илүү ажилласнаар тооцож 4,646,858.00 /дөрвөн сая зургаан зуун дөчин зургаан мянга найман зуун тавин найман/ төгрөг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3 “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий 2 ажилтанд илүү олгосон 4,646,858.00 /дөрвөн сая зургаан зуун дөчин зургаан мянга найман зуун тавин найман/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар¹т ирүүлэхийг Монгол Солонгосын политехникийн коллежийн захирал /Э.Түмэндэмбэрэл/, ахлах нягтлан бодогч /Ц.Ариунжаргал/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Akr\2026\0225 SAG-20.Docx

1526200083



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 26/A0150458

Улаанбаатар хот

САГ-2026/108/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Солонгосын политехникийн коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд коллежийн хавсралтад дурдсан нэр бүхий 3 ажилтанд ээлжийн амралттай байх хугацаанд 1,529,369.00 /нэг сая таван зуун хорин есөн мянга гурван зуун жаран есөн/ төгрөгийн цалин хөлсийг давхардуулан илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 "ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ээлжийн амралтын хугацаанд давхардуулан олгосон 1,529,369.00 /нэг сая таван зуун хорин есөн мянга гурван зуун жаран есөн/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Солонгосын политехникийн коллежийн захирал /Э.Түмэндэмбэрэл/, ахлах нягтлан бодогч /Ц.Ариунжаргал/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

К.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\kri\2026\0225 SAG-20.Docx

1526200085



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 163/АД150458

Улаанбаатар хот

САГ-2026/108/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Солонгосын политехникийн коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жолоочийн замын хуудас бүрэн хөтлөөгүй, шатахууны тооцоог бодоогүй, шатахууны зарцуулалтын тайлан гаргаагүй нийт 13,810,600.00 /арван гурван сая найман зуун арван мянга зургаан зуун/ төгрөгийн шатахуун зарцуулсан байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1 "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасны бүртгэл бүрэн хөтлөөгүй, тооцоо бодолгүйгээр шатахуун олгож байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Солонгосын политехникийн коллежийн захирал /Э.Түмэндэмбэрэл/, ахлах нягтлан бодогч /Ц.Ариунжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-24.Docx

1526180472



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 162/АД150458

Улаанбаатар хот

САГ-2026/108/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Солонгосын политехникийн коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын даргын 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/130 дугаар тушаалаар эд хөрөнгийн тооллого хийхээр тооллогын комиссыг томилж, тооллого хийсэн боловч хөрөнгө тоолсон тухай илтгэх хуудас, тооллогын тайлан, тооцоо бодсон акт үйлдээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" 73 дугаар зүйлийн 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2 "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тооллогын үр дүнг хэлэлцэж, тооцоог бодоогүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Солонгосын политехникийн коллежийн захирал /Э.Түмэндэмбэрэл/, ахлах нягтлан бодогч /Ц.Ариунжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

998157
АТГ16087
9025051911

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-24.Docx

152618077